

ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

2019.12.03

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүд болох үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани, даатгагч болон даатгагчийн мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч зэрэг нь УИХ-аас 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталсан Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д “Хүн, хуулийн этгээд аливаа үйлчилгээ үзүүлэхдээ хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцааж тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье.

Хууль тогтоомжоор хүлээсэн мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 9-д “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс, эсхүл төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хуульд заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн арга хэмжээ авах нөхцөл үүсэхийг анхааруулж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО